



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2012 05 оны 30 сарын 30 өдөр

Дугаар 1/19

Улаанбаатар хот

Бизнес инкубатор төв байгуулах,
дүрэм батлах тухай


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.9.2 дахь заалт, Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бизнес инкубацын чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Бизнес инкубатор төв”-ийг байгуулсугай.
2. “Бизнес инкубаторын төв”-ийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Төвийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусгуулан, бизнес инкубацын үйлчилгээг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулж үр дүнг хагас жил тутам тайлагнаж ажиллахыг орлогч дарга /Б.Сүнгээ/-д даалгасугай.

ДАРГА  Г.БАТСАЙХАН



Нийслэлийн Хөдөлмөрийн газрын
2012 оны 04 дугаар сарын 30 ны
өдрийн /11/ тоот тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРЫН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ дүрэм нь “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубатор төв”-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын өмчлөл, түүнийг өөрчлөн байгуулах зэрэгтэй холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулах баримт бичиг мөн.

1.2 “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубатор төв”-ийн /цаашид “Бизнес инкубатор төв” гэх/ гол зорилго нь бизнес эрхлэхийг хүсэгч болон шинэ тутам байгуулагдсан аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч иргэдийг шинэ жижиг бизнест хөгжлийн эмзэг болон төвөгтэй эхний үе шатуудыг даван туулах, цаашлаад өсөлтөнд хүрэх хүртэл бойжуулан зах зээлд өрсөлдөх чадвартай болгож гаргах, үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж мэргэжилтэй болгон өрхийн үйлдвэрлэл эрхлүүлэх, байнгын ажлын байранд зуучлах замаар ажлын байр шинээр бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн төсөвт Улсын үйлдвэрийн газар мөн.

1.3 “Бизнес инкубатор төв” нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхэлдэг орон нутгийн төсөвт Улсын үйлдвэрийн газар бөгөөд төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан ажиллана.

1.4 “Бизнес инкубатор төв” нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулиуд болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд, тухайн жилийн нийгэм, эдийн засгийн зорилтыг үйл ажиллагаандаа баримтлана.

Хоёр. Хэлбэр, оноосон нэр, байршил, тэмдэг

2.1 “Бизнес инкубатор төв” нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас ашиглана.

2.2 “Бизнес инкубатор төв” нь санхүүгийн тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, тусгайлсан эд хөрөнгөтэй хуулийн этгээд мөн.

2.3 Оноосон нэр нь орон нутгийн төсөвт Улсын үйлдвэрийн газар болох “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубатор төв”, товчилсон нэр нь “Нийслэлийн Хөдөлмөрийн газрын дэргэдэх бизнес инкубатор төв” байна.

2.4 Албан ёсны хаяг: Чингэлтэй дүүрэг, бага тойруу-15, Улаанбаатар бизнес хөгжлийн төв, 3 давхар,

Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1 . Бизнес инкубатор төв нь дараахи үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

3.1.1 Төвийн дотоод үйл ажиллагаа

- Бойжигчийг бойжуулаад “гаргах” бодлогыг тодорхойлох,
- Шаталсан түрээсийн бодлогыг боловсруулах
- Хөнгөлөлтийн өөрчлөлтийн бодлого боловсруулах
- Хүрэх ёстой өсөлтийн зорилтуудыг тодорхойлох
- Төв нь хөдөлмөр эрхлэлтийн талаархи хууль, тогтоомж, төсөл, хөтөлбөрөөс дэмжлэг авна.
- Мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх баг, иргэдийн сүлжээтэй байх
- Тусгай бүлгүүдийн эрэлт хэрэгцээг хангах боломжийг судлах
- Ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгчдийн клуб байгуулах, клубын гишүүдийн хамтын ажиллагааг дэмжих
- Бойжигчдын бараа бүтээгдэхүүн борлуулах сүлжээ байгуулах
- Бойжигчийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тооцон тайлагнаж байх
- Төв нь хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн үйл ажиллагаа явуулж тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.
- Төвийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бололцоог хангах ажлыг зохион байгуулах
- Төв нь орчин үеийн дэвшилтэт технологи, стандартыг ажил үйлчилгээндээ нэвтрүүлнэ.
- Үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор гадаад ба дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулна.

3.1.2 Бойжигчдод чиглэсэн үйл ажиллагаа

- Бойжигчийг сонгон шалгаруулах, хамтран ажиллах
- Бойжигч болох хүсэгчдийн судалгаа гаргах, чадварыг тогтоох
- Байрны хөнгөлттэй түрээсийн үйлчилгээ
- Суурь тоног төхөөрөмжийн ашиглалтаар үйлчлэх
- Бизнес /багийн, ганцаарчилсан, дадлагын, мэргэжлийн/ сургалтуудыг зохион байгуулах
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- Төсөл хөтөлбөр, бизнесийн орчны судалгаа, бизнес төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулах, сурталчилах, үзэсгэлэн худалдаанд оролцох, тоног төхөөрөмж авахад нь зуучлах
- Маркетинг, рекламны үйлчилгээ үзүүлэх, түншлэл, бизнес эрхлэгчдийн сүлжээ олоход туслах
- Олон талт, шинэ технологийн мэдээллийн үйлчилгээ
- Оффисын суурь тоног төхөөрөмжийн үйлчилгээ

- Хуулийн этгээдийг бүртгүүлэх, баримт бичгийг бэлтгэж өгөх
- Бизнес эхлэн эрхлэгчдэд нягтлан бодогчийн туслалцаа үзүүлэх
- Захиргаа болон хууль эрх зүйн асуудлуудыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- Бойжигч байгууллагуудын бизнесийн яриа, уулзалт, семинарыг зохион байгуулах
- Хөнгөлттэй зээлд зуучлах, хөрөнгийн баталгаа гаргах

Дөрөв. Эд хөрөнгийн үндсэн эрх

4.1 “Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэдэх бизнес инкубатор төв”-ийн эд хөрөнгө нь НХГ-н даргын шийдвэрээр НХГ-н өмчөөс эзэмшүүлсэн төвийн барилга, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, өөрийн үйл ажиллагааны үр дүн болон төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон эд хөрөнгөөс бүрдэнэ.

4.2 “Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэдэх бизнес инкубатор төв” нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр дараах эрх үүрэгтэй. Үүнд:

4.2.1 Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмших, ашиглах

4.2.2 Хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд захиран зарцуулах

Тав. Удирдлага зохион байгуулалтын бүтэц

5.1 НХГ нь төвийг байгуулах, өөрчлөх, татан буулгах ба төвийн дүрмийг батална.

5.2 “Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэдэх бизнес инкубатор төв”-ийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг НХГ-н дарга баталж, үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавина.

5.3 “Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэдэх бизнес инкубатор төв”-ийн захирлыг НХГ-н даргын шийдвэрээр томилж, чөлөөлнө.

5.4 “Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэдэх бизнес инкубатор төв”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдаж, төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллана.

5.5 “Нийслэлийн хөдөлмөрийн газрын дэргэдэх бизнес инкубатор төв” нь “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-д заасан журмын дагуу нэмэлт орлого олж болно.

5.6 НХГ нь Бизнес инкубатор төвийн бизнес инкубацын үйлчилгээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

5.7 “НХГ –н дэргэдэх БИТ” нь үйл ажиллагааны дотоод дүрэм, хөдөлмөрийн дотоод журамтай байх ба түүнийг төвийн нийт ажилтан, төвд бойжигчид өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

5.8 “НХГ –н дэргэдэх БИТ”-ийн захирал нь дор дурдсан эрхийг эдэлнэ. Үүнд:

5.8.1 НХГ-н баталсан удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарын хүрээнд ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх

5.9.2 “НХГ –н дэргэдэх -ийн БИТ”-ийн эрхэм зорилго, зорилт, стратеги, чиг хандлага, зорилтот үзүүлэлтүүдийг тодорхойлох, төлөвлөгөө боловсруулах, төвийн салбаруудыг өргөтгөх, шинэчлэх, төлөвлөгөөт болон урсгал засвар, үндсэн хөрөнгийг ашиглалтад оруулах бодлого боловсруулах

5.8.3 ” НХГ –н дэргэдэх БИТ”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, салбаруудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, өдөр тутмын болон стратегийн үйл ажиллагаатай холбогдсон тушаал шийдвэр гаргаж, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах

5.8.4 Эрх хэмжээнийхээ хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах

5.8.5 Захирал нь ажил, үйлчилгээг төсвийн ерөнхийлөн захирагчид бүтээгдэхүүний хэлбэрээр нийлүүлж, ажлын үр дүнгээр шагнал, урамшуулал авна.

5.8.6 ”НХГ –н дэргэдэх БИТ”-ийн захирал нь санхүүгийн үйл ажиллагааг зохистой удирдаж, төвийн мөнгөн хөрөнгийн зарлагын урсгалыг удирдах, санхүүгийн баримт бичигт нэгдүгээр гарын үсэг зурах, хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрх хэмжээндээ захиран зарцуулах

5.8.7 “НХГ –н дэргэдэх БИТ”-ийн ажиллагчдын бүрэн эрх, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал урамшил, хариуцлагын хэмжээг тогтоох

5.8.8 Хууль тогтоомж болон гэрээгээр олгогдсон бусад эрхийг хэрэгжүүлж ажиллах

5.8.9 “НХГ –н дэргэдэх БИТ”-д бойжигчдийн санал хүсэлт , өргөдөл гомдлыг эцэслэн шийдвэрлэх

5.8.10 “НХГ –н дэргэдэх БИТ”-д бойжигчдийн ажлын чанар, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шаардлагад хяналт, шаардлага тавих

5.9 “НХГ –н дэргэдэх БИТ”-ийн захирал нь дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

5.9.1 Захирал нь “НХГ –н дэргэдэх БИТ”-ийн үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр дүүргийн НХГ тайлагнана.

5.9.2 Хууль тогтоомжийн хүрээнд “НХГ –н дэргэдэх БИТ”-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хангуулах

5.9.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд хүргэж сурталчилах

5.9.4 Холбогдох хууль журмын дагуу хүлээсэн үүрэг

5.10 НХГ –н дэргэдэх БИТ-ийн захирлын хүлээх хариуцлага:

5.10.1 НХГ –н дэргэдэх БИТ-ийн захирал бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн тохиолдолд Хөдөлмөрийн тухай болон Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Зургаа. Санхүү, бүртгэл тайлан

6.1 “НХГ –н дэргэдэх БИТ” нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

6.2 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг төвийн захирал, нягтлан бодогч нар хариуцана.

6.3 Санхүүгийн тайланд дараахи зүйлийг хамруулан ойлгоно.

- Баланс
- Орлого, үр дүнгийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Хуримтлагдсан ашгийн тайлан
- Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт
- Нэмэлт тайлбар
- Бусад

6.4 Төвийн захирал Нийслэлийн өмчийн харилцааны газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлагнах ба тайланд дараахи зүйлийг тусгана. Үүнд:

- Тайлангийн хугацаанд орон нутгийн төсөвт улсын үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаархи танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт
- Тайлангийн хугацаанд орон нутгийн төсөвт улсын үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажиллагсадад олгосон шагнал, урамшил, удирдлагын зардлын хэмжээ, шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар

Долоо. “НХГ –н дэргэдэх БИТ” орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрыг татан буулгах

7.1 НХГ-н болон шүүхийн шийдвэр, холбогдох хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгана.

Найм. Бусад

8.1 Энэхүү дүрэмд НХГ-н даргын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2 Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

8.3 Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

8.4 Дүрэм нь батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болно.